

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт	6
2.9. Зорилтот түвшний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	12
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	12
2.12. Шилэн дансны мэдээлэл	12
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3. Менежментийн захидал	14
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	17
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	17
4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	19
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТӨҮГ	Төрийн өмчийн үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.03.13 № 06/840
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монголросцветмет ТӨҮГ- нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б. Мөнхбат танд танилцуулж байна,

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн өр төлбөрийн үлдэгдлийг бүрэн баталгаажуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх, компанийн үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг нэр төрөл, үзүүлэлт бүрээр нь жигд ханган биелүүлж, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, түрээсийн гуравласан гэрээг ТӨБЗГ-аар батлуулах зэрэг зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Монголросцветмет” ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 15-наас 2020 оны 3 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Ол деш хайрхан аудит ХХК-ийн аудитор Г. Рэнцэнханд, Ц. Бумцэнд нар хариуцан хэрэгжүүлэв.

Монголросцветмет ТӨҮГ 2019 оны санхүүгийн тайлангаа 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 1/386 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголросцветмет ТӨҮГ нь “Уул уурхай, хайлуур жонш, алт болон бусад ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах чиглэлээр дэлхийд өрсөлдөхүйц, олон улсын жишигт хүрсэн засаглал, технологи, чадавх бүхий үйлдвэр болох, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжих” гэж тодорхойлжээ.

Монголросцветмет ТӨҮГ-ын дүрмийг Засгийн газрын 2019 оны 103 дугаар тогтоолоор шинэчлэн баталж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хайлуур жонш, алт болон бусад ашигт малтмал олборлох, баяжуулах, борлуулах;
- Баяжмал болон бусад бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах;
- Үйлдвэрлэсэн баяжмалыг металлургийн аргаар боловсруулах;
- МУ-ын нутаг дэвсгэр дээр геологи хайгуулын ажил, явуулах ашигт малтмалын орд газрыг үйлдвэрлэлийн аргаар эзэмшихэд бэлтгэх, ашиглах;
- Барилгын зураг төслийн ажил хийх, барилга байгууламж угсралт, монтаж, тохируулгын ажил гүйцэтгэх;
- Гадаадад бүтээгдэхүүнээ экспортлох, аж ахуйн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай материал, техник төхөөрөмж, импортлох;
- Дотоод, гадаадын үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулж, гэрээний нөхцөлийн дагуу тэдэнд зөвлөх болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэх;
- Үйлдвэрийн газар нь үндсэн болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болно;
- Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэхээр бол эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрлийг авч улсын бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль
- ХХОАТ-ын тухай хууль
- Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 103 дугаар тогтоолоор Монголросцветмет ХХК-ийг төрийн өмчийн үйлдвэрийн газар болгон өөрчилсөн.
- Монголросцветмет ТӨҮГ-ын дүрэм
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3,9 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 103 дугаар тогтоолын 3 дахь заалт, Монголросцветмет ТӨҮГ-ын дүрмийн 5.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 4 дүгээр сарын 2-ны 91 дүгээр тогтоолоор тус ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг баталсан байна.

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 4 дүгээр сарын 2-ны 91 дүгээр тогтоол, Монголросцветмет ТӨҮГ-ын дүрмийн 5.12, 6.10 дахь заалтыг үндэслэн Шижир Алт ХХК-ийг татан буулгаж, нэгтгэсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монголросцветмет ТӨҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Даймонд” программ хангамж ашигладаг байна.

Монголросцветмет ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Монголросцветмет” ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн 79,210.0 сая төгрөгөөс тооцон 792.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлаас 1.0 хувиар тооцож 1,038.0 сая төгрөгөөр тогтоолоо.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

“Монголросцветмет” ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,191.5 сая төгрөгөөр буюу 42.7 хувиар өссөн байна.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,355.0	11,598.5	7,243.5
Дансны авлага	1,834.7	1,676.4	(158.3)
Татвар, НДШ-ийн авлага	1,667.2	284.0	(1,383.2)
Бараа материал	22,143.9	37,970.8	15,826.9
Урьдчилж төлсөн зардал	3,479.8	5,717.0	2,237.2
Үндсэн хөрөнгө	28,381.3	36,735.5	8,354.2
Биет бус хөрөнгө	2,139.3	1,931.2	(208.1)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,158.8		(2,158.8)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	3,097.3	3,335.4	238.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө		200.0	200.0
Дуусаагүй барилга	1,445.6	1,445.6	-
Нийт хөрөнгийн дүн	70,702.9	100,894.4	30,191.5
Дансны өглөг	9,690.2	9,009.5	(680.7)
Цалингийн өглөг	953.3	1,754.8	801.5
Татварын өр	5,195.4	3,548.6	(1,646.8)
НДШ-ийн өглөг	1,459.8	425.3	(1,034.5)
Богино хугацаат зээл	25,880.6	20,651.8	(5,228.8)
Хүүгийн өглөг	44.1		(44.1)
Ногдол ашгийн өглөг	1,371.3		(1,371.3)
Урьдчилж орсон орлого	10,718.8	13,512.6	2,793.8
Бусад өр төлбөр	2,026.4	1,431.9	(594.5)
Урт хугацаат өр төлбөр	11,235.6	11,235.6	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,127.4	39,324.3	37,196.9
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	70,702.9	100,894.4	30,191.5

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,243.5 сая төгрөгөөр өссөн нь орлогын өсөлтөөс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 1,541.5 сая төгрөгөөр буурсан нь авлага барагдуулах ажлын хэсэг байгуулан холбогдох арга хэмжээ авч ажилласан, мөн орлогын өсөлтөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2013-2017 онуудад үүссэн, он удаан жил болсон 358.8 сая төгрөгийн

байгууллага, хувь хүнээс авах авлага байна. Үүнээс 312.9 сая төгрөгийн авлагыг шүүх байгууллагаар шийдвэрлүүлж, шүүхийн шийдвэрийн дагуу хэсэгчлэн барагдаж байна. 46.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан авах авлагыг барагдуулснаар Татвар, НДШ-ийн авлага 1,383.2 сая төгрөгөөр буурч оны эцэст 284.0 сая төгрөг болсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,826.8 сая төгрөгөөр өссөн нь жилийн эцсийн байдлаар 11,327.7 сая төгрөгийн өртөг бүхий 83.9 мянган тн жоншны хүдэр, 319.1 мянган тн төмрийн хүдэр, 7,565.2 сая төгрөгийн үлдэгдэл бүхий бэлэн бүтээгдэхүүн, 10,029.2 сая төгрөгийн өртөг бүхий сэлбэг хэрэгсэл, 6,921.8 сая төгрөгийн өртөг бүхий хангамжийн материал, 2,064.9 сая төгрөгийн өртөг бүхий шатах тослох материал бүртгэгдсэн нь нийт бараа материал 15,826.9 сая төгрөгөөр нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 2016 оноос өмнө худалдаж авсан ашиглалтгүй 2,024.7 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл байна. Энэ нь бараа материалын нийт үлдэгдлийн 5.3 хувийг эзэлж байна. Үйлдвэрлэлд шаардлагагүй дээрх сэлбэгүүд нь бараа материалын эргэцийг удаашруулах, агуулахын үлдэгдлийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай байна.

Урьдчилж төлсөн зардал өссөн нь “Зэрэгцээ” алтны үйлдвэр Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-020945 тоот тусгай зөвшөөрлийн талбайд дээр 2019 оноос эхлэн ажилласнаар үндсэн үйлдвэрлэлийн зардалд 314.0 сая төгрөг, уулын бэлтгэл ажил болон тээвэрлэлтийн зардалд 1,378.0 сая төгрөг нийт 1,692.0 сая төгрөгийн, “Бор-Өндөр” УБҮ 263.3 сая төгрөгийн уулын бэлтгэл ажлын зардал гаргаж тайлант үед нийт 1,955.3 сая төгрөгийн зардал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,354.2 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар 8,055.3 сая төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй 79.2 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна. Тайланд онд 306.0 сая төгрөг хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэн, 5,166.2 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө нь оны эхнээс буурсан байна. Монголросцветмет ТӨҮГ нь 23 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 3 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж, 15,086.0 га газар бүхий талбайд үйл ажиллагаа явуулж байна. Засгийн газрын 2019 оны 28 тоот тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК-д Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын нутагт байрлах Асгатын мөнгөний ордны MV-000278, MV-008645, MV-004388, MV-008191 тоот тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлсэн байна. Засгийн газрын шийдвэрээр Баянхонгор аймгийн Түйн голын алтны шороон ордын XV-003959, XV-004211 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн нөхөн төлбөрт авсан Төв аймгийн Заамар суманд орших хайгуулын талбайд үйл ажиллагаа явуулах боломж бий болж биет бус хөрөнгөд бүртгэлтэй байсан 432.3 сая төгрөгийн тусгай зөвшөөрлийн төлбөрийг хассан нь бие бус хөрөнгө буурахад голлон нөлөөлжээ.

Өмнөх жилүүдэд үүссэн татварын өглөгийг 1,646.9 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийг 1,034.5 сая төгрөгөөр, арилжааны банкны зээлийг 5,228.8 сая төгрөгөөр, зээлийн хүү болон ногдол ашгийн өглөгийг 1,415.4 сая төгрөгөөр тус тус барагдуулснаас шалтгаалан нийт богино хугацаат өр төлбөр 7,005.4 сая төгрөгөөр буурсан байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т төлөх 11,080.2 сая төгрөгийн өр байна.

Дансны өглөг үлдэгдэлд 2019 онд үүссэн 27.8 сая төгрөгийн цахилгааны барьцаа хөрөнгө нийт өр төлбөрийн 0.3 хувийг эзэлж байна. Бусад 8,981.7 сая төгрөгийн өр үйлдвэрлэлд шаардлагатай сэлбэг, бараа материал, тоног төхөөрөмжийг зээлээр худалдан авснаас үүссэн байна.

Дансны өглөг тайлант хугацаанд 680.7 сая төгрөгөөр буурч жилийн эцсийн байдлаар 9,009.5 сая төгрөг байгаа нь нийт өр төлбөрийн 14.6 хувийг эзэлж байна. Төрийн өмчит үйлдвэрийн газар нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй ажиллаж байгаа энэ үед бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өр төлбөрийг төлж барагдуулах талаар анхаарч ажиллах нь зүйтэй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 39,234.3 сая төгрөг болж 37,107.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 34,446.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласантай холбоотой байна.

Ингэснээр 2019 оны эхэнд байсан 11,364.6 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдлыг бүрэн барагдуулж, Төрийн өмчит үйлдвэрийг газрыг 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 25,832.4 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажиллах нөхцөл боломжийг бий болгосон байна.

2.9. Зорилтот түвшний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д заасны дагуу хөрөнгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, удирдлага нь энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, үүргийг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2019 оны 4 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 92 дугаар тогтоолоор баталсан байна. Энэхүү батлагдсан төлөвлөгөөг 6 дугаар сарын 18-ны 264 тоот тогтоолоор, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 8 дугаар сарын 29-ны 340 тоот тогтоолоор тус тус тодотгон баталж, хэрэгжилтийг ханган биелүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний дагуу 2019 онд нийтдээ 157.2 тэрбум төгрөгийн орлоготой ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 143.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж 91.5 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж, 22.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаас гүйцэтгэлээр 34.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан, улсын төсөвт 22.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 33.4 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Энэ нь төлөвлөгөөт цэвэр ашгийн хэмжээг 12.4 тэрбум төгрөгөөр буюу 56.0 хувиар, төсөвт төвлөрүүлэх татвар төлбөрийн хэмжээг 11.3 тэрбум төгрөгөөр буюу 51.0 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Хүснэгт 2. Борлуулалтын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Флотацын баяжмал ФФ-95	33,697.6	19,297.5	-14,400.1	57.3
Бүхэллэг жонш ФК-75	2,154.6	249.2	-1,905.4	11.6
Алт /Зэрэгцээ АУ/	9,969.6	1,358.3	-8,611.3	25.3
Төмрийн нойтон баяжмал /Fe-65%/	22,406.8	29,743.2	7,336.4	86.4
Төмрийн хуурай баяжмал /Fe-52%/	24,588.5	25,118.7	530.2	102.2
Төмрийн хүдэр	62,851.0	62,480.4	-370.6	99.4
Туслах үйлдвэрлэлийн орлого	1,399.3	1,664.6	265.3	119.0
Бусад	119.9	3,943.2	3,823.3	3288.2
Нийт дүн	157,187.5	143,855.3	-13,332.2	91.5

Нийт орлого 13,332.2 сая төгрөгөөр тасарсан нь дараах хүчин зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

- ФФ-95 флотацын баяжмалын гол худалдан авагч нь ОХУ-ын “Галополимер” компани бөгөөд бүтээгдэхүүний үнэ болон бусад хүчин зүйлсээс хамаарч 2019 оны борлуулалтын гэрээ хийгдээгүйгээс ФФ-95 баяжмалын борлуулалтын орлого 14,400.0 сая төгрөгөөр тасарч 57.3 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Бүхэллэг жонш ФК-75 нь ФФ-95 маркийн флотацын баяжмалын үйлдвэрлэлийн технологийн явцад үйлдвэрлэгддэг тул мөн дээрх хүчин зүйлсээс хамаарч борлуулалтын орлого 1,905.5 сая төгрөгөөр тасарч 11.6 хувийн биелэлттэй байна.
- Алтны борлуулалтын орлогын төлөвлөгөө 8.6 сая төгрөгөөр тасарсан байна. Алт олборлолтын үйл ажиллагааг 2019 оны 04 дүгээр сарын 01-ээс 2019 оны 11 дүгээр сарын 01-ний хооронд нийтдээ 7 сарын хугацаанд зохион байгуулахаар төлөвлөж ажилласан боловч гүйцэтгэлээр 2019 оны 09 дүгээр сарын 02-ноос 2019 оны 11 дүгээр сарын 23-ны хооронд ажилласан байна. Энэ нь худалдан авах ажиллагаа төлөвлөсөн хугацаанаас хоцорсноос тоног төхөөрөмж, сэлбэг, материалын хангалт хугацаандаа хийгдээгүй, байгаа уулын техник тоног төхөөрөмж хуучирсан насжилт ихтэй, сэргээн засварлах ажлын гүйцэтгэл их байсан зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байна.
- Харин ФФ-95 маркийн флотацын баяжмал үйлдвэрлэхээр төлөвлөсөн хугацаанд Fe-65 төмрийн нойтон баяжмал үйлдвэрлэн борлуулснаар борлуулалтын орлого 7,336.4 сая төгрөгөөр буюу 32.7 хувиар давж биелсэн,
- Fe-52 төмрийн хуурай баяжмалын борлуулалтын орлогын төлөвлөгөө 530.2 сая төгрөгөөр буюу 2.2 хувиар давж биелжээ.

Нийт зардлын төсөв 125,508.9 сая төгрөг байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 106,364.8 сая төгрөгийн зардалтай ажилласан байна.

Хүснэгт 3. Зардлын гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Зардлын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү, +, -	биелэлтийн хувь
	Худалдаж авсан түүхий эд материал	4,130.0	595.2	3,534.8	14.4
1	Материалын зардал:	24,517.5	18,966.3	5,551.2	77.4
	а) Туслах материал	19,585.9	15,083.9	4,502.0	77.0
	б) Сэлбэг материал	3,555.3	3,051.1	504.2	85.8
	в) Дугуй	1,376.3	831.4	544.9	60.4
2	Шатах тослох материал	14,783.2	10,638.1	4,145.1	72.0
	а) Дизель түлш	10,099.9	8,051.7	2,048.2	79.7
	б) Бензин	450.0	441.3	8.7	98.1
	в) Тослох материал	1,762.2	578.9	1,183.3	32.8
	г) Мазут	949.6	460.1	489.5	48.5
	д) Нүүрс	1,521.5	1,106.0	415.5	72.7
3	Цахилгаан эрчим хүч	9,499.9	9,936.9	437.0	104.6
4	Цалин хөлс	35,405.2	32,001.3	3,403.9	90.4
5	ЭМНД шимтгэл	5,133.7	4,391.1	742.6	85.5
6	Элэгдэл хорогдлын шимтгэл	6,421.6	5,503.3	918.3	85.7
7	Бусад мөнгөн зардал	25,617.7	24,332.5	1,285.2	95.0
	НИЙТ ЗАРДАЛ	125,508.9	106,364.8	19,144.1	84.7

Нийт зардлын гүйцэтгэл 84.7 хувьтай байгаа нь жоншны баяжмал үйлдвэрлэлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс шалтгаалсан байна. Мөн худалдан авах ажиллагаа хойшлогдсоноос зарим техник тоног төхөөрөмжийн нийлүүлэлт удааширснаас төмрийн хүдэр олборлолт дахь хөрс хуулалтын ажил хоцорсон зэрэг нь зардлын гүйцэтгэлд нөлөөлжээ.

Удирдлагын зардлыг 6,405.1 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 98.7% буюу 6,319.8 сая төгрөгийг зарцуулсан, борлуулалт маркетингийн зардлыг 17,244.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 15,372.3 сая төгрөгийг зарцуулж 10.9% буюу 1,872.2 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувьд тайлант хугацаанд нийтдээ жоншны флотацын баяжмал 41.6 мян.тн үйлдвэрлэхээс 16.1 мян.тонныг үйлдвэрлэж 38.7%-ийн гүйцэтгэлтэй, төмрийн хүдрийн баяжмал 316.3 мян.тонныг үйлдвэрлэхээс 388.8 мян.тн үйлдвэрлэж 123%-ийн гүйцэтгэлтэй, алт 99.8 кг олборлохоос 10.7 кг-ыг олборлож 11 хувийн гүйцэтгэлтэй, төмрийн хүдэр 2,400.0 мян.тн олборлохоос 2,437.6 мян.тн олборлож 102.0%-ийн гүйцэтгэлтэй байна.

“Монголросцветмет” ТӨҮГ-ын гадаад болон дотоодын зах зээлд нийлүүлж буй бүтээгдэхүүн борлуулалтын үйл ажиллагааны гүйцэтгэл:

- Төмрийн баяжмалын экспорт 364.8 мян.тн буюу 91% гүйцэтгэлтэй,
- Хайлуур жоншны баяжмалын экспорт 22.3 мян.тн буюу 48% гүйцэтгэлтэй,
- Төмрийн хүдрийн борлуулалт 1,639.7 мян.тн буюу 83% гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 18,802.3 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 12,443.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 12,443.6 сая төгрөг буюу 66.2 хувьтай байгаа нь Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны зорилтот түвшин, худалдан авалт, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр баталснаас шалтгаалан худалдан авах үйл ажиллагаа оройтож эхэлсэнтэй холбоотой байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 12 эрсдэл тодорхойлж нийт 12 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 83.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн эргэц, өмч хөрөнгөд тавих дотоод хяналт сайжруулах, дараах асуудлуудад байгууллагын удирдлага анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Он удаан жил болсон өр, авлагын асуудлыг шийдвэрлэх ажил бүрэн хийгдээгүй;
- Ашиглах боломжгүй, агуулахад хадгалагдаж эргэлтийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх тухай аудитын зөвлөмж хүргүүлсэн боловч бүрэн шийдэгдээгүй;
- Зарим нэрийн бүтээгдэхүүний олборлолт, борлуулалтын орлогын төлөвлөгөө тасарсан.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Монголросцветмет ТӨҮГ-нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Энэхүү үүргээ хэрэгжүүлэх үүднээс зарим арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд.

Тус ТӨҮГ нь шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний 103 тоот тогтоолоор Монголросцветмет ХХК-ийн хариуцлагын хэлбэр өөрчлөгдөж ТӨҮГ болсон тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн цэсэд өөрчлөлт оруулах хүсэлт хүргүүлж, мэдээллийг байршуулах эрхээ авсан байна.

Монголросцветмет ТӨҮГ-ын захирлын 2019 оны 4 дүгээр сарын 17-ны А/228 тоот тушаалаар мэдээллийг хариуцах, хянах ажилтнуудыг томилж, ажилтан бүрд код олгосон, Үндэсний Аудитын Газарт шилэн дансны мэдээллийн талаарх сургалт зохион байгуулах хүсэлтийг хүргүүлснээр нийт 15 ажилтан сургалтад хамрагдсан байна. 2019 онд холбогдох мэдээллийг бүрэн байршуулжээ.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн, 464.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монголросцветмет ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант оны эцэст дансны 9,009.5 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй гарсан. Үүнээс 0.92 хувь буюу 83.0 сая төгрөгийн үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй байна. Өмнөх онд үүссэн өр төлбөрөөс 5,806.5 сая төгрөгийн өрийг барагдуулж, 5,057.3 сая төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн байна.

Өглөгийн үлдэгдлийг бүрэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Өр төлбөрийн үлдэгдлийг бүрэн баталгаажуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийн хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

3.2.1 Илрүүлэлт:

Монголросцветмет ТӨҮГ түрээслэгч байгууллагатай үл хөдлөх хөрөнгийн талбай түрээслэх гэрээ байгуулсан, гуравласан гэрээг ТӨБЗГ-аар баталгаажуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 28.5, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын холбогдох заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төрийн өмчийг түрээслүүлэхдээ ТӨБЗГ-тай гуравласан гэрээ байгуулаагүй байх, түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Түрээсийн гуравласан гэрээг ТӨБЗГ -аар батлуулж байх

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Харьяа үйлдвэрүүдэд хадгалагдаж байгаа хэрэгцээ шаардлага хангахгүй, дахин ашиглагдах боломжгүй сэлбэг, хангамжийн материал, бараа материалын үлдэгдэл байгаа нь ашиглалтгүй эргэлтийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл, эргэцэд зохих хэмжээгээр нөлөөлөхөөр байна. Ашиглалтын шаардлага хангахгүй болсон сэлбэг, хангамжийн материалын үлдэгдлийн судалгааг гаргаж шийдвэрлүүлэх ажил хийгдээгүй байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, СТОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1.1- д “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.” гэж заасан зэргийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3.2 Эрсдэл:

Бараа материал сэлбэг хэрэгслийн дансанд ашиглагдахгүй сэлбэг үлдэгдэлтэй байх, хөрөнгийн бодит үнэ цэнээр нь үнэлээгүй байх, холбогдох хууль, заавар, журмыг мөрдөж ажиллаагүй байх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа эргэлтийн хөрөнгийг данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Орлогын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: Хайлуур жоншны бүтээгдэхүүний борлуулалт-52.1 хувиар, төмрийн баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт -8.8 хувиар, төмрийн хүдрийн борлуулалт-17.8 хувиар, алтны олборлолт-89.3 хувиар тус тус тасарсан байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг төлөвлөгөөтэй харьцуулахад жоншны баяжмал 54.8 хувь тасарсан бол төмрийн нойтон баяжмал 31.3 хувиар төмрийн хуурай баяжмал 15.7 хувиар тус тус давж биелсэн байна.

Энэ нь Монголросцветмет ТӨҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 01 тоот тогтоол, ТӨБЗГ-тай байгуулсан 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн бизнес төлөвлөгөөг нэр төрөл, үзүүлэлт бүрээр ханган биелүүлээгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Байгууллагын орлогын төлөвлөгөө биелээгүй байх,

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Компанийн үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг нэр төрөл, үзүүлэлт бүрээр нь жигд ханган биелүүлж, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,355,003,139.19	11,598,491,533.84
1.1.2	Дансны авлага	1,834,675,213.57	1,676,366,507.90
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,667,198,353.74	284,034,587.57
1.1.6	Бараа материал	22,143,901,759.60	37,970,766,635.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,479,760,972.81	5,717,025,381.20
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	33,480,539,438.91	57,246,684,646.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,381,306,725.04	36,735,531,008.66
1.2.2	Биет бус хөрөнгө	2,139,283,610.82	1,931,202,512.20
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,158,820,000.00	
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	3,097,281,327.12	3,335,367,094.62
1.2.6	Бусад эргэлтийн бус хөрөнгө		200,000,000.00
1.2.9	Дуусаагүй барилга	1,445,635,002.83	1,445,635,002.83
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	37,222,326,665.81	43,647,735,618.31
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	70,702,866,104.72	100,894,420,264.51
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	9,690,203,133.91	9,009,480,315.42
2.1.1.2	Цалингийн өглөг	953,294,322.00	1,754,799,788.58
2.1.1.3	Татварын өр	5,195,447,981.23	3,548,557,473.76
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,459,789,883.83	425,331,283.64
2.1.1.5	Богино хугацаат зээл	25,880,597,991.14	20,651,800,000.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	44,063,408.25	
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	1,371,317,600.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	10,718,806,758.09	13,512,602,336.93
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	2,019,186,993.36	1,427,409,313.99
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	7,209,446.10	4,515,858.32
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	57,339,917,517.91	50,334,496,370.64
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	155,340,343.09	155,340,343.09
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	11,080,236,150.00	11,080,236,150.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,235,576,493.09	11,235,576,493.09
2.2	Өр төлбөрийн нийт дүн	68,575,494,011.00	61,570,072,863.73
2.3	2. Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч : а) төрийн	1,226,788,000.00	1,226,788,000.00
2.3.2	б) хувийн		

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,265,209,146.83	12,265,209,146.83
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-11,364,625,053.11	25,832,350,253.95
2.3.9.1	Тайлангийн үеийн	7,842,831,381.38	34,446,224,049.16
2.3.9.2	Өмнөх үеийн	-19,207,456,434.49	-8,613,873,795.21
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	<u>2,127,372,093.72</u>	<u>39,324,347,400.78</u>
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>70,702,866,104.72</u>	<u>100,894,420,264.51</u>

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2019 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	82,215,408,292.06	138,247,349,832.51
2	Борлуулалтын өртөг	50,081,891,323.91	62,438,456,686.15
3	Нийт ашиг (алдагдал)	32,133,516,968.15	75,808,893,146.36
4	Түрээсийн орлого	913,275,809.37	362,798,967.65
5	Хүүгийн орлого	46,061,597.58	226,020,070.28
8	Бусад орлого	4,097,778,866.22	4,824,559,209.98
9	Борлуулалт, маркетингийн зардал	11,866,423,553.90	15,372,337,801.23
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,179,008,517.79	6,319,806,801.02
11	Санхүүгийн зардал	1,791,281,383.81	3,683,634,121.30
12	Бусад зардал	7,420,560,303.69	8,508,203,400.71
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(218,176,956.09)	194,537,891.59
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(247,688.85)	(12,392,118.30)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	11,714,934,837.19	47,520,435,043.30
19	Орлогын татварын зардал	3,872,103,455.81	13,074,210,994.14
20	Татварын дараах ашиг (алдагдал)	7,842,831,381.38	34,446,224,049.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,842,831,381.38	34,446,224,049.16

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	- 17,636,138,834.49	- 4,144,141,687.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			7,842,831,381.38	7,842,831,381.38
Зарласан ногдол ашиг			-1,571,317,600.00	-1,571,317,600.00
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	- 11,364,625,053.11	2,127,372,093.72
Нягтлан бодох бүртгэлтийг бодогын өөрчлөлтийн нөлөө, алдаагы залруулга			4,319,317,534.18	4,319,317,534.18
Залруулсан үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	-7,045,307,518.93	6,446,689,627.89
Ногдол ашиг			-1,568,566,276.28	-1,568,566,276.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			34,446,224,049.16	34,446,224,049.16
2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	1,226,788,000.00	12,265,209,146.82	25,832,350,253.95	39,324,347,400.77

4.4. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	94,387,552,206.60	157,376,964,567.18
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	91,050,618,678.53	150,656,996,851.32
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,779,089.00	8,952,060.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,330,154,439.07	6,711,015,655.86
1.2	Мөнгөн зарлагын дүн	(92,826,664,661.32)	(137,785,606,271.46)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(19,076,489,533.76)	(27,854,757,292.75)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(8,121,488,147.43)	(8,622,467,530.87)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(15,262,545,549.11)	(28,670,981,269.58)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(13,579,033,539.12)	(15,811,558,006.15)
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(15,021,848,028.19)	(23,687,647,983.18)
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	(1,752,075,585.79)	(3,678,875,521.29)
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(12,181,754,231.64)	(28,721,077,462.29)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(53,721,671.00)	(69,411,481.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(7,777,708,375.27)	(668,829,724.35)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,560,887,545.28	19,591,358,295.72
2.1	Мөнгөн орлогын дүн	46,062,013.37	224,604,420.43
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	46,062,013.37	224,604,420.43
2.2	Мөнгөн зарлагын дүн	(1,778,985,487.24)	(4,944,091,449.81)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,778,985,487.24)	(4,944,091,449.81)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,732,923,473.87)	(4,719,487,029.38)
3.1	Мөнгөн орлогын дүн	22,191,800,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	22,191,800,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	(19,896,071,251.31)	(8,168,680,356.41)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(19,696,071,251.31)	(5,228,796,480.13)
3.2.4	Төлсөн ногдол ашиг	(200,000,000.00)	(2,939,883,876.28)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,295,728,748.69	(8,168,680,356.41)
4	Валютын ханшийн зөрүү	90,682,204.68	540,297,484.72
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,214,375,024.78	7,243,488,394.65
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,140,628,114.41	4,355,003,139.19
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,355,003,139.19	11,598,491,533.84

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.03.09	Аудитын нэр:	Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Монголросцветмет ТӨҮГ			САГ-2020/105/СТА-ТӨҮГ
				сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	<p>Борлуулалтын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл: Хайлуур жоншны бүтээгдэхүүний борлуулалт-52.1 хувиар, төмрийн баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт - 8.8 хувиар, төмрийн хүдрийн борлуулалт-17.8 хувиар, алтны олборлолт-89.3 хувиар тус тус тасарсан байна.</p> <p>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг төлөвлөгөөтэй харьцуулахад жоншны баяжмал 54.8 хувь тасарсан бол төмрийн нойтон баяжмал 31.3 хувиар төмрийн хуурай баяжмал 15.7 хувиар тус тус давж биелсэн байна. Энэ нь Монголросцветмет ТӨҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 01 тоот тогтоол, ТӨБЗГ-тай байгуулсан 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн бизнес төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлээгүй байна.</p>		Зөрчлийг давтан гаргахгүй байх, ТУЗ-ийн тогтоол, ТӨБЗГ-тай байгуулсан бизнес төлөвлөгөөг нэр төрөл, үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б. Мөнхбат, Д. Баярбат

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

2	<p>2019 онд нийт 387.8 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлсэн байна. Үүнээс үл хөдлөх хөрөнгө түрээсэлсний талбайн түрээсийг 10 аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулж 95.6 сая төгрөгийн орлого олсноос 30% буюу 28.6 сая төгрөгийг ТӨБЗГ-т төвлөрүүлж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Монголросцветмет ТӨҮГ түрээслэгч байгууллагатай үл хөдлөх хөрөнгийн талбай түрээслэх гэрээ байгуулсан, боловч гуравласан гэрээг ТӨБЗГ баталгаажуулаагүй байна. Энэ нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна ТБОНӨ-ийн тухай хуулийн 28.5, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын холбогдох заалт тус тус зөрчсөн байна.</p>		Зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б. Мөнхбат, Д. Баярбат
3	<p>Харьяа үйлдвэрүүдэд хадгалагдаж байгаа хэрэгцээ шаардлага хангахгүй, марилын элэгдэлд орсон зарим сэлбэг, хангамжийн материал, бараа материалын үлдэгдэл байгаа нь ашиглалтгүй эргэлтийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл, эргэцэд зохих хэмжээгээр нөлөөлөхөөр байна. Иймд ашиглалтын шаардлага хангахгүй болсон сэлбэг, хангамжийн материалын үлдэгдлийн судалгааг гаргаж шийдвэрлүүлэх ажил хийгдээгүй байна.</p> <p>Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна СТОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тус тус зөрчсөн байна.</p>		Зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хуулийн заалтыг хэрэгжүүлэх	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б. Мөнхбат, Д. Баярбат
4	<p>"Монголросцветмет" ТӨҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 1,676,366.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс 0,76 хувь буюу 12.1 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажууллаа.</p> <p>Нийт дансны авлагын 24.9 хувь буюу 411,037.0 мянган төгрөгийн авлага нь 2012-2018 онд үүссэн авлага эзэлж байна. Тайлант онд өмнөх оны авлагаас 1,207,757.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 1,049,449.1 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.</p>	83.0	Авлага, өглөг үүсгэхгүй байх, он удаан жил болсон авлага, өглөгийг барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үлдэгдлийг тооцоо ийлсэн актаар баталгаажуулах	Захирал, Ерөнхий нягтлан бодогч	Б. Мөнхбат Д. Баярбат

Монголросцветмет ТӨҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

	<p>Тайлант оны эцэст дансны 9,009,480.63 мянган төгрөгийн өрийн үлдэгдэлтэй гарсан. Үүнээс 0,92 хувь буюу 83,052.8 мянган төгрөгийн үлдэгдлийг актаар баталгаажуулаагүй байна.. Өмнөх онд үүссэн өр төлбөрөөс 5,806,532.6 мянган төгрөгийн өрийг барагдуулж, 5,057,373.9 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн байна.</p> <p>Өглөгийн үлдэгдлийг бүрэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>				
	Дүн	83.0			

